

Одоо Хятад оронд болж байгаа нийгэм эдийн засаг дахь өөрчлөлтийн үйл явцаас үзвэл дээр дурдсан хүчин зүйлүүдийг зохицуулах үүднээс тал бүрийн арга хэмжээ авч байгаа нь ажиглагдаж байна.

1. «Хунци» 1987. № 19 хуудас 23-24
2. Мөн тэнд
3. «Хунци» 1987 19 х-23
4. «Жэньминь жибао» 1988. II. 24
5. «Хунци» 1987 № 19 х-24
6. «Хунци» 1987 № 19 х-23

ЗҮҮН ӨМНӨД АЗИЙН ХОЛБОО (АСЕАН)-НЫ ОРНУУДЫН ЭДИЙН ЗАСАГ

Ч. СУВД

Сүүлийн жилүүдэд Ази, Номхон далайн бүс нутгийн аюулгүй байдал бүхэлдээ, Зүүн өмнөд Азийнх тусгайдаа ихээхэн анхаарал татах боллоо. Үүний учир шалтгаан нь нэгд Ази номхон далайн сав нутагт дэлхийн хүн амын ихэнх нь амьдардаг, 33 улс оршдоогоороо, хоёрт эдгээр орнуудад дэлхийд нээж олсон хөнгөн цагааны 56%, никель цайрын 41%, кобальтын 37%, зэсийн 32%,¹ далайн ёроолын нефть, хийн боломжит нөөцийн 30—40 %² нь болон бусад ашигт малтмалын ихээхэн нөөц байгаа, мөн дэлхийн худалдааны эргэлтийн гуравны нэгээс илүү оногдож байгаагаар, гуравт НҮБ-ын мэргэжилтнүүдийн тооцоолсноор дэлхийн аж үйлдвэрийн нэгэн том төв болох ирээдүйтэйгээр, дөрөвт дэлхийн II дайнаас хойш АНУ-аас хийсэн хоёр том дайн (Солонгос, Энэтхэг-Хятадын хойгт) болсон төдийгүй өнөө хэр нь «халуун цэг», «маргаантай асуудал» гэгчийн учиг сэжүүр болж ирснээр тайлбарлагдана.

Зүүн өмнөд Ази нь Номхон далайн орнуудын хоорондын харилцаа, хамтын ажиллагаа, аюулгүй байдалд төдийгүй, даян дэлхийн энх амгаан, аюулгүй байдалд хүртэл нөлөөлж, том, жижиг, улсуудын ашиг сонирхол огтолцож мөргөлдсөн бүс нутаг юм. Тус бүс нутагт дэлхийн социалист хоёр том гүрэн-ЗСБНХУ, БНХАУ, мөн дэлхийн капитализмын гурван тулгуурын хоёр нь болох АНУ, Япон хил залган оршдог. Мөн үүний хамт арал ольтригийн жижиг улсууд ч бий.

Нэг үе дэлхийн энх тайван, аюулгүй байдалд ноцтой заналхийлэл бий болж, нэг үе итгэл найдвар, хэвийн амьдрал ээлжлэн солигдож байлаа. «Долгион» маягийн тэсрэмтгий шинж нь дэлхийн олон нийтийн, тэр дундаас Ази тивд оршдог манай орны анхаарлыг зүй ёсоор татдаг юм.

Бруней, Индонез, Малайз, Сингапур, Тайланд, Филиппиныг багтаасан АСЕАН-ын орнууд нь Ази номхон далайн орнуудын түгшүүртэй байдлыг намжаах, энх тайван, аюулгүй байдлыг бэхжүүлэхэд эдийн засаг, улс төрийн томоохон хүч мөн. Сүүлийн жилүүдэд АСЕАН-ы орнууд нь бүс нутгийн төдийгүй даян дэлхийн улс хоорондын харилцаанд хүндтэй

байр эзэлж, онцгой анхаарал татах болсон нь хэд хэдэн учир шалтгаантай юм. Нэгд АСЕАН-ы орнууд нь номхон далайн сав нутагт оршдогийн хувьд урин дулаан уур амьсгалтай төдийгүй, хөрсөн дороо ч, усан дороо ч ховор ашигт малтмал, нетфь, хийн арвин их нөөцтэй юм. Хоёрт харьцангуй хямд, тэгэхдээ муугүй мэргэшсэн ажиллах хүчний нөөцтэй улсууд юм. Энэ хоёр хүчин зүйлийн нөлөөгөөр АСЕАН-ы орнуудын эдийн засаг сэргээд зогсохгүй түргэн хурдацтай өсөх төлөвийг олов. Сүүлийн үед эдгээр орны хөрөнгө үлэмж нэмэгдсэн бөгөөд гол хөрөнгө оруулагч орон нь Япон болно. Японы гадаадад оруулж буй хөрөнгө оруулалтын дөрөв ний нэг буюу 13,5 тэр бум долларыг зөвхөн Зүүн өмнөд Азид оруулжээ³. Мөн түүнчлэн АСЕАН-ы орнуудын гадаад хөрөнгө оруулалтын 23 хувь нь АНУ-д, 14-15 хувь нь нийтийн зах зээлийн орнуудад оногдож байна. Японы хөрөнгө оруулалт нэг үе Индонезид зонхилж байсан бол одоо Тайландад дараа нь Сингапур, Малайзад оногдох болов. Асар их хөрөнгө оруулалтын үр дүнд эдгээр улс эдийн засгийн хөгжлийн хур- дацаараа хөгжиж буй орнууд дотроо тэргүүлж байна. Үүнийг дараах хүснэгтээс харж болно.

**АСЕАН-Ы ОРНУУДЫН ҮНДЭСНИЙ ОРЛОГЫН
ЖИЛИЙН ДУНДАЖ ӨСӨЛТ⁴**

	1950-1960	1960-1970	1970-1975	1975-1980
Бруней	9,0	5,5	12,8	10,2
Сингапур	7,7	9,7	7,6	11,0
Малайз	3,6	6,4	10,4	8,6
Филиппин	6,3	5,2	6,2	6,2
Тайланд	5,7	7,9	8,2	6,3

Капитализмын ерөнхий хямрал гүнзгийрсээр байгаа нөхцөлд эдгээр орон түргэн хурдацтай хөгжиж, «шинэ аж үйлдвэрийн» орнууд гэж нэрлэгдэх болов. Жишээлбэл: 1984 онд Индонез улс 69 сая тонн нефть, 1 сая т. боксит, 1,3 сая т. никелийн хүдэр, 23,2 мянган т, цагаан тугалганы баяжмал,⁵ Малайз 700 мянган т, боксит, 14 сая т. нефть, 200 мянган т. төмрийн хүдэр, 41 мянган т цагаан тугалга⁶, Филиппин 1983 онд 41,1 мянган т никелийн, 273 мянган т, зэсийн, 4,2 мянган т, цайрын хүдэр, 1,2 сая тчулуун нүүрс⁷, Бруней 9 сая т, нефть, 13 тэр бум м3 байгалийн хий⁸ тус тус олборлож байв.

АСЕАН-ы орны үйлдвэржүүлэлтийн гүнзгийрэлт нь аж үйлдвэрийн өндөр хурдцаас гадна боловсруулах үйлдвэрийн өсөлт, дэлхийн зах зээлд өрсөлдөх чадвараар бас тодорхойлогдож байна. АСЕАН цахилгаан эрчим хүч, мод боловсруулалт, нефть химийн, цементийн үйлдвэрүүд түүгээр ч зогсохгүй автомашин, онгоц, радиотехник, компьютерийн угсралтын үйлдвэрүүд хөгжиж бүтээгдэхүүнээ экспортлож байна. «Зургаагийн» нийт үндэсний орлогын тавны нэг илүүг боловсруулах үйлдвэрт, харин экспортын 30 орчим хувийг бэлэн бүтээгдэхүүн эзлэх болов.⁹

Гэвч сүүлийн жилүүдэд эдгээр орны үндэсний орлогын жилийн дундаж өсөлт буурч байна. Жишээлбэл 1981-1983 онд Сингапурын үндэсний орлогын жилийн дундаж өсөлт 0,6—6,0; Малайзынх 7,1—5,9; Филиппиных 3,9-1,1; Тайландынх 6,3-5,8; Индонезийнх 7,9—4,2 хувь хүртэл буурав¹⁰. Энэ нь нэг талаас хөгжиж буй орнуудад дэлхийн капитализмын гурван төвөөс (АНУ, Япон, Баруун Европын хөгжингүй капиталист орнууд) үзүүлж буй шахалт хавчилт «хамтын шинэ колоничлол» даамжирч тэдэнд ашигтай бусаар зах зээлийн үнэ өөрчлөгдөж ирснээр, нөгөө талаар эдгээр орны эдийн засаг нь өрөөсгөлдүү чиглэлтэй, явцуу бүтэцтэй байгаагаар тайлбарлагдана.

Хөдөө аж ахуй бол АСЕАН-ы орнуудын ууган бөгөөд шийдвэрлэх ач холбогдол бүхий салбар юм. Малайзын эдийн засгийн идэвхтэй хүн амын 45,4%, Филиппины 43,9%, Тайландын 73,9%, Индонезийн 56,5%, нь хөдөө аж ахуйд ажиллаж байгаа¹¹ бөгөөд гол төлөв газар тариалан эрхэлдэг. Тухайлбал Индонез 1985 онд 26,3 сая т. цагаан будаа хурааж өөрийнхөө хэрэгцээг бүрэн хангаж байв. Мөн 2 сая т, загас барьж, 25 сая м³ мод боловсруулж, 1,1 сая т, каучук үйлдвэрлэж байлаа¹². Малайз 1983 онд 1,3 сая т, цэвэрлэсэн цагаан будаа хурааж, хэрэгцээнийхээ тавны дөрвийг хангаж байсны дээр 700-800 мянган т. загас барьж, 3,5 сая т хүртэл наргилын тос (экспортын чухал эх үүсвэр) 1,6 сая т. каучук¹³, Тайланд 1985 онд 20 сая т, цагаан будаа 4,4 сая т, эрдэнэ шиш, 23 сая т. чихрийн манжин хурааж 600 сая т. жинхэнэ каучук үйлдвэрлэж байлаа¹⁴.

АСЕАН-ы орнуудын эдийн засгийн амьдралд тээврийн салбарын гүйцэтгэх үүрэг улам бүр нэмэгдэж байна. Ялангуяа усан болон агаарын тээвэр нь тухайн орныхоо хэрэгцээг хангаад зогсохгүй бүс нутгийнхаа, цаашилбал олон улсын харилцаа, худалдаанд бодитой нэмэр хандив оруулж байна. Тайланд, Индонез, Малайз, Филиппин, Сингапурын аль нь ч усан замын томоохон боомт хотуудтай, худалдааны флоттой юм. Тэдгээр нь сайтар тоноглогдсон, жилдээ олон зуун мянган ачаа тээвэрлэх чадвартай. Мөн түүнчлэн авто замын болон төмөр замын сүлжээ ч өргөнжиж байна.

АСЕАН-ы орнуудын эдийн засгийн амьдралд гарсан нэгэн сонин бөгөөд ирээдүйтэй зүйл бол олон улсын аялал жуулчлал, түүнд үйлчлэх үйлчилгээний өсөлт юм. Энэ зорилгоор олон зуун зочид буудал барьж, Түүх-соёлын үнэт зүйлсийг сэргээж, авто замын сүлжээг боловсронгуй болгон, агаарын тээврийг хөгжүүлж байна. Олон улын жуулчлал нь «зургаагийн» орнуудын валютын чухал эх үүсвэр болж, цаашид ч нэмэгдэх хандлагатай байна.

АСЕАН-ы орнуудын нийгэм-эдийн засгийн амьдралд хэдийнээс нааш гадаад худалдаа нэн чухал үүрэгтэй байсаар ирсэн юм. Энэ нь хоёр талтай. Нэгдэх нь гэвэл тус бүс нутгийн байгууллагын гишүүн орнуудын хоорондын, нөгөө нь гэвэл хөгжингүй капиталист орнуудын хоорондын харилцаа юм. АСЕАН-ы орнуудын эдийн засгийн хөгжилд ажиглагдаж буй өөр нэгэн онцлог бол аж үйлдвэржүүлэлтийг дагалдан бүс нутгийн худалдаа өргөжиж байгаа явдал мөн. Наяад оны эхэнд Ази, Номхон далайн орнуудын хэмжээн дэх экспортын 52 %, импортын 54 % нь¹⁵ АСЕАН-ы орнуудад оногдож байв.

АСЕАН-ы орнуудын хоорондын худалдаа нь тэдний санаанд хүрэхгүй байгаагийн голлох шалтгаан нь эдийн засгийн хөгжлийн түвшинд нь биш, харин АНУ, Япон зэрэг хөгжингүй капиталист түншийн шахалт дарамтаас үүдэн гарч буй Япон бол АСЕАН-ы орнуудын экспорт-импор-

тын гол түнш юм. Японоос Ази, Номхон далайн орнуудад үзүүлж буй тусламжийн тэн хагас, зээллэгийн 35 хувь нь АСЕАН-д оногдож байна. АСЕАН-ы орнууд Японы хэрэгцээт жинхэнэ каучукийн 98 %, тосны 96 %, боксит, зэсний 30 %, нефтийн 12—13 хувийг нийлүүлж байна¹⁶. АСЕАН-ы орнуудтай Японы дараа орох АНУ-ын худалдаа 1967 онд 967 сая доллар байснаа 1985 онд 24 миллиард долларт хүрчээ. Гэвч АНУ-ын гадаад худалдааны эргэлтийн тавхан хувь нь АСЕАН-д оногдож байгаа болно.

АНУ, Японы эрх баригчид АСЕАН-ы орнуудыг түүхий эдийнхээ бааз байлгахыг хичээж, үндэстэн дамнасан корпорнуудынхаа төрөл бүрийн арга дэвийн тусламжтайгаар (нефть, жинхэнэ каучук, чихэр, цагаан будаа, самрын тос г. м.) түүхий эдийнх нь үнийг буулгаж, өөрсдийн тоног төхөөрөмж, технологийн үнийг нэмж байна. Мөн импортоор хясах, банкны зээл, хүүгээр далдуур мөлжих явдал ихсэв.

АСЕАН-ы орнуудын гадаад худалдааны түншүүд солигдож, байн байн байраа өөрчилж ирснийг дурдууштай. Тухайлбал, сүүлийн хорин жилд Тайланд, Индонезийн экспорт, импортын гүйлгээнд Япон улс тэргүүлэх байр эзэлж байхад далаад оны эхээр Малайзын гадаад худалдаанд нийтийн зах зээлийн орнууд, далаад оны хуучаар эдний оронд Япон, далаад оны дундуур Сингапурын экспортын дийлэнх нь нийтийн зах зээлийн орнуудад оногдож байснаа одоо АНУ-д оногдох болов. АСЕАН-ы орнуудын зах зээлд Англи, Франц, Голландын капитал ч түрэн орж ирлээ.

Бүхэлд нь авч үзвэл далаад онд нийтийн зах зээлийн орнуудын капитал Латин америкийн орнууд руу хандлагатай байсан бол одоо «зургаагийн» зах зээл рүү хошуурах болов. Энэ бүхнээс үүдээд АСЕАН-ы орнууд, хөгжингүй капиталист орнуудын хоорондын зөрчил гүнзгийрч, улам бүр хайр найргүй сорон мөлжигч шинжтэй болж байна.

Сүүлийн жилүүдэд хөгжингүй капиталист орнуудын амьдралд зуршмал байдаг хүнд хэцүү үе дахин илрэх болов. Жишээ нь: АНУ-ын гадаад өр улам бүр хяналтаас гарч, сүүлийн арван таван жилд (1970—1985) АНУ-ын гадаад худалдааны алдагдал 150 тэрбум доллар болтлоо хуримтлагдав¹⁷.

Бүрэлдэн бий болсон нөхцөл байдлаас гарз хохиролгүй гарахын тулд АНУ-ын сенатын орлого, зарлагын хороо АСЕАН-ы орнуудаас нийлүүлж байгаа хямд төсөр, өрсөлдөх чадвартай сүлжмэлийн үйлдвэрийн бүтээгдэхүүн, хувцасны импортыг 40 хувиар хорогдуулсан нь Филиппин, Индонез, Сингапурыг сүрхий цочирдуулав. Америкийн импортод эдгээр орны сүлжмэл үйлдвэрийн бүтээгдэхүүн ердөө 2,7-хон хувийг эзэлдэг байтал эдгээр оронд, АНУ-ын гаргаж буй экспортын, ялангуяа Филиппинд гаргасан зүйлийн 65 хувь нь бэлэн хувцас байв.¹⁸

Америкийн империализм, японы милитаризмын өөр нэгэн арга мэх нь хөнгөлттэй зээл гэгч юм. Зүүн өмнөд Ази дахь байраа бэхжүүлж зах зээлээ алдахгүйн тулд төрөл бүрийн хөнгөлттэй зээл, «Хөгжлийн программ» гэгчийг санал болгож байна. Тухайлбал: АСЕАН-ы орнуудад 1983 онд 800 гаруй сая иены олон улсын хөгжил, шинэчлэлтийн банк (ОУХШБ) 1984 онд Филиппинд 230 сая долларын зээл олгож, хөнгөлөлт зээлийн оронд 1985 онд 140 сая т. цагаан будаа авахыг санал болгож байв. Индонез 1987 оны 11 сард японоос 900, ОУХШБ-аас 300, мөн оны V сард Олон улсын валютын фондоос (ОУВФ) 610 сая долларын зээл авахаар шийдвэрлэжээ¹⁹. Гэтэл ийм зээлийн үнэн байдлыг сонирхох юм бол Филиппины хөдөө аж ахуйг хөгжүүлэхэд ОУХШБ-аас олгосон

сайхь 230 сая долларыг 36 хувийн хүүтэйгээр төлөх нөхцөл нь Тайланд, Индонезид худалдах тонн цагаан будааны өртгөөс үнэтэй байх ажээ. Тэгээд ч зогсохгүй АНУ-ын химийн бордооны хяналтыг Филиппинд олгох зээлийн бас нэг болзол болгожээ.

АСЕАН-ы орнуудын эдийн засгийн амьдралын өөр нэгэн «содон» шинж бол өр төлбөрийн өсөлт юм. 1985 оны байдлаар Индонезын²⁰ гадаадад тавьсан өр 23, Тайландынх 19, Филиппиных 26, Малайзынх 21 тэрбум доллар байв²¹. Ийнхүү АСЕАН-ы орнуудын гадаадад тавьсан өр сүүлийн жилүүдэд хорогдохгүй, харин ч нэмэгдэж 100 миллиардад дөхөж очив.²² Вашингтоны шахалт шаардлагын улмаас АСЕАН-ы орнуудын хоорондын хийгээд капиталист гол орнуудтай харилцах эдийн засаг, техник, соёлын харилцаа хумигдаж, хоёрдугаар зэргийн шинжтэй болж, цэргийн зардал түргэн нэмэгдэх хандлага хурлаар илрэх болов. Хэдийгээр АСЕАН цэргийн эвсэл болон хувираагүй ч гэсэн АНУ-ын империализм, Японы милитаристууд түүнийг цэрэг дайны эргүүлгэнд татан оруулахыг идэвхтэй чармайж байна. Нэг талаас АСЕАН-ы орнуудын цэргийн зардлыг нэмэгдүүлж, нөгөө талаас тэдгээр орны цэргийг НАТО гийн «стандарчилалд» хүргэхийг хичээж байгаа бөгөөд энд АНУ-тай ойр дотно цэргийн холбоотой байдаг. Тайландыг үлгэр жишээ болгож байна. Тайландад АНУ-ын цэргийн бааз байрлаад зогсохгүй Тайландыг Энэтхэг-Хятадын хойгийн орнуудтай сөргөлдөхөд илэрхий дэмжиж, хамгийн орчин үеийн зэвсэг техникээр тэтгэж байлаа.

Сүүлийн жилүүдэд АСЕАН-ы орнуудад үзүүлэх цэргийн тусламж өсөж ирлээ. 1985 онд АНУ-ын конгресс АСЕАН-ы орнуудтай хийх техникийн хамтын ажиллагаанд 4,8 сая доллар олгосон мөртлөө Филиппины цэргийн программд зориулан 180 сая доллар, Тайландад 100 сая доллар, Индонезид 43 сая, Малайзид 11 сая доллар олгожээ. Үүний улмаас сүүлийн үед АСЕАН-ы орнуудын ялангуяа Тайландын цэргийн төсөв 3 дахин нэмэгдэж, 1,7 млрд доллар болжээ.²³ Лондоны стратегийн судалгааны институтын мэдээгээр бол Индонез, Сингапур, Тайланд, Малайзын цэргийн зардал 1978 оныхоос далаад хувиар нэмэгдэж, 8 млрд гаруй доллар болжээ. Тэдгээр орны зэвсэгт хүчний тоо 800 мянгаас давсан байна. Энэ хүү зэвсэгт хүчнийг зэвсэглэхэд ойрын арван жилд 10 млрд долларын зэвсэг техник шаардагдах²⁴ бөгөөд 6 млрд долларын өртөг бүхий зэвсгийг АНУ 1990 он гэхэд худалдахаар байна.²⁵ Гэвч энэ нь анхнаасаа эдийн засаг, техник, соёлын харилцааны шинжтэй бус харин цэрэг-улс төрийн бодлогод, Токио-Вашингтоны «тэнхлэгт» баригдмал учир тар нь танигдаж, өргөн олон нийт, тэр дундаас АСЕАН-ы орнуудын дургүйцлийг төрүүлсэн юм.

АСЕАН-ы орнуудын хүн ам сүүлийн 25 жилд 173-аас 289 саяд хүрч, 1.6 дахин өссөн юм.²⁶ Хүн ам зүйчдийн тооцоолж байгаагаар 2000 он гэхэд АСЕАН-ы орнуудын бүх хүн ам 400 сая болох ажээ.²⁷ Энэ нь нэгэн бодлын сайн, нөгөө бодлын хэцүү зүйл. Нэгдэх нь гэвэл нас залуу, хямдагтар ажиллах хүчний нөөц байнга хүрэлцээтэй байна гэсэн үг. Нөгөө нь гэвэл хөдөлмөрийн насанд олон саяараа шилжин ирж буй залуучуудыг ажлаар бүрэн хангах асуудал юм. Хүн ам зүйн боломжит нөөц, эдийн засгийн бодит чадавхи хоёрын хооронд багагүй зөрүү байгаа нь итгэл найдвар, зовнил түгшүүрийн аль алиныг төрүүлж байна. Ганц жишээ хэлэхэд албан ёсны мэдээгээр Тайландад ажилгүйчүүд эдийн засгийн идэвхтэй хүн амын 7 хувийг эзэлж байна.²⁸ Үүнд улирлын чанартай ажилладаг хөдөө аж ахуйн олон сая ажиллагчид ороогүй юм.

Эдгээр орны хөдөө аж ахуйн салбар нь одоо ч, цаашид ч ихээхэн хэмжээний ажиллах хүчнийг өөртөө татах нь эргэлзээгүй. Гэхдээ хэргийн учир хөдөө аж ахуйг хөгжүүлэхэд бус, харин орчин үеийн эдийн засгийн инфра бүтцийг бүрэлдүүлэн хөгжүүлэхэд оршино. Тус бүс нутгийн ор нуудын хөгжилд сонин сонин туршилтууд хийгдэж байна. Тухайлбал, Тайланд улс бараг л аж үйлдвэржүүлэлтийг дамжилгүйгээр хөдөө аж ахуйн орноос үйлдвэржсэн үйлчилгээний эдийн засаг тийш үсрэлт хийж, улс орныхоо хөгжлийг түргэтгэх, хүндрэл бэрхшээлийг гэтлэн давах талаар амжилтад хүрэв. Индонез улс модон материалын үйлдвэрлэлийг хөгжүүлж сайн чанарын фанер экспортолсны хүчинд неф тийн экспортын орлоготой бараг тэнцэх 6,7 сая долларын бүтээгдэхүүн гаргав. Түүнчлэн «зургаагийн» зарим орнууд материалын ч биш, түүхийн Эдийн ч биш, харин чухамхүү шинжлэх ухааны багтаамжтай электроник автоматжуулалт, авто болон нефть химийн орчин үеийн үйлдвэрийг хөгжүүлд байна. Гэвч АСЕАН-ы орнуудын нийгэм эдийн засгийн хөгжил хөгжингүй капиталист орнуудаас хоцроод зогсохгүй өөр хоорондоо ч ихээхэн ялгаатай юм.

1. Проблемы Дальнего Востока 1987. №3 57 дугаар тал
2. Международная жизнь 1986. №6 107 дугаар тал
3. Проблемы Дальнего Востока 1988 №1 155 дугаар тал
4. Б. М. Болотин, В. Л. Шейнис. Экономика развивающихся стран в цифрах М. 1988. 385-390 дүгээр тал
5. Страны мира М. 1986 171 дүгээр тал
6. Мөн тэнд 218 дугаар тал
7. Мөн тэнд 255 дугаар тал
8. Мөн тэнд 152 дугаар тал
9. Проблемы Дальнего Востока 1987. №3 57 дугаар тал
10. Б. М. Болотин, В. Л. Шейние. Экономика развивающихся стран в цифрах М, 1988 385-390 дүгээр тал
11. Мөн тэнд 281-291 дүгээр тал
12. Страны Мира М, 1986, 170 дугаар тал
13. Мөн тэнд 218 дугаар тал
14. Мөн тэнд 248 дугаар тал
15. Проблемы Дальнего Востока 1984 №2 158 дугаар тал
16. "Asia week", 1985. 7. 19
17. Проблемы Дальнего Востока 1988. №1 158 дугаар тал
18. Мөн тэнд
19. Far Eastern Economic Review 1987. 5. 14
20. Страны мира М, 1986. 171 дүгээр тал
21. За рубежом 1987. №4
22. «Нихон Кэйдзай» 1986. 6. 3.
23. Азия Африка сегодня 1985, №9
24. Красная звезда 1983. 6. 13
25. Социалистическая индустрия 1986. 716.
26. Б. М. Болотин, В. Л. Шейнис. Экономика развивающихся стран в цифрах М, 1988. 272-275 дугаар тал
27. Проблемы Дальнего Востока 1988 №1
28. За рубежом 1988. №19